



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 4/24

Дэлгэрхаан сум

2026 онд сумын ойн сангаас мод
бэлтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь хэсэг, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын ойн сангаас 2026 онд мод бэлтгэн (ойн мэргэжлийн байгууллагатай) гэрээ байгуулан ажиллахыг "Үндэсний ойжилт" хариуцлагатай хувьцаат компанид зөвшөөрсүгэй.

2.Үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг хариуцсан нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагчдад, мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (У.Ариунтуяа)-д үүрэг болгосугай.

3.Ойн мэргэжлийн байгууллагуудын мод бэлтгэлд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах, тайланг сар, улирлаар гаргаж холбогдох байгууллагад хүргэж ажиллахыг байгаль хамгаалагч (Х.Мөнхбат)-д даалгасугай.

ДАРГА  Б.ЭНХ-АМГАЛАН

2326010049

